

## 1. ҮГ НЬ БУРХАН БАЙСАН (Иохан 1:1-18)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** (А) Хэрэв энэхүү Баярт Мэдээний судалгааны групп Библи огт мэддэггүй хүмүүс байвал таныг энэ хэсгээр эхлэхгүй байхыг зөвлөе. Энэ нь эхлэгчдэд нэн хэцүү юм. (Б) Зөвхөн эхний асуултанд хэн ч хариулаагүй үед л хашилтан дах асуултыг асуух ёстой.

### 1. Үг (ишлэл 1-3, 14)

- Эдгээр дөрвөн ишлэлүүдийн утгыг өөрийн үгээр тайлбарла.
- Хоёр хүний нөхөрлөлд “үг” ямар ач холбогдолтой гэжи та боддог вэ?
- Яагаад “үг” Христчин хүний итгэлд хамгийн чухал вэ? Мөн энэ нь яагаад хэлэх, мэдрэхээс илүү чухал вэ?
- Хэрэв бидэнд Бурханы Үг байхгүй байсан бол бид хэрхэн Бурханыг мэдэж чадах байв?
- Яагаад Есүсийг Бурханы Үг гэж нэрлэдэг вэ?

### 2. Гэрэл (ишлэл 4-10)

- Ишлэл 4-5 ямар утгатай вэ?
- Гэрэл Есүстэй юугаараа адилхан бэ?
- Харанхуй гэрлийг дийлсэнгүй гэдэг нь ямар утгатай вэ? (Ишлэл 5 ба холбогдох тайлбар)
- Хэдийгээр Тэр харанхуйд гэрэл гэгээ болон “гэрэлтэж” байсан ч ертөнц яагаад Есүсийг таньсангүй вэ? (ишлэл 10)

### 3. Баптист Иохан (ишлэл 6-8)

- Энэ хэсгийн дагуу Баптист Иохан ямар үүрэгтэй байсан бэ?
- Баптист Иохан өөрөө тэр гэрэл байгаагүй гэдэг нь ямар утгатай вэ? (Ишлэл 8)
  - Иохан “Би бол гэрэл” гэж хэлээгүй. Тэр яаж ийнхүү даруу байж чадсан бэ?
- Иоханы үүргийг Бурханы хаанчлал дахь өөрийн үүрэгтэй харьцуул.

### 4. Ертөнц ба Бурханы хүүхдүүд (Ишлэл 9-13)

- Энэ хэсгийн дагуу “ертөнц” гэдэг нь ямар газар вэ?
- Энэ хэсгийн дагуу хүн хэрхэн Бурханы хүүхэд болдог вэ? (Яагаад энгийн төрөлтөөр хэн ч Бурханы хүүхэд болж болохгүй вэ?)
- Та аль хэдийн Бурханы хүүхэд болсон уу? Хэрвээ тийм бол хэрхэн болсон бэ? (Та үүнийг өөрийн зүрх сэтгэлдээ хариулж болно.)

### 5. Иоханы гэрчлэл (ишлэл 15-18)

- Баптист Иохан Есүсийн талаар юу гэрчилснийг өөрийн үгээр хэлнэ үү.
- Та ишлэл 16 бол таны амьдралын үнэн гэсэн гэрчлэлийг зөвшөөрч чадах уу?
- Иоханы хэлсний дагуу “бид Бурханыг мэдэхэд суралцаж чадна” гэсэн нь ямар ганц утгатай вэ?
- Та энэхүү библийн хэсгийг ойлгосон бол (Иохан 1:1-18) бол Иудейцууд, Мусламчууд болон Христэд итгэгч нэр бүгд нэг бурхантай гэсэн талаар юу гэж бодож байна вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс ба Үг бол нэг бөгөөд адил зүйл. Хэрэв та Библийн үгийг өөрийн амьдралдаа хүлээн авдаг бол Христийн хүлээн авдаг. Хэрэв та Библийг үл үгүйсгэвэл Христийг үгүйсгэнэ. Есүсийн Үг бол гэрэл бөгөөд өнөөдөр ч гэсэн адил таны доторх харанхуйг гэрэлтүүлж байна. Зөвхөн энэ үгнээс та “нигүүсэл дээрээ нигүүслийг” хүлээн авдаг.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 2. БИД МЕССИАГ ОЛСОН (Иохан 1:43-51)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Газрын зураг дээр Бетан (1:28), Бетсайд (1:44) ба Назарийн (1:46) байрладаг газрыг хар. Хуучин Гэрээн дээр Еврейгээр “Назар” (Исаиа 11:1, 53:2, Иеремия 23:5, 33:15) гэсэн үгтэй маш төстэй “мөчир” гэсэн үгнээс өөрөөр Назарыг мессиаг зөгнөлтэй холбон дурдаагүй. Удирдагч нь урьдчилан Иакобын шатны түүхийг (Эхлэл 28:10-22) унших ёстой. Учир нь сүүлчийн асуулт үүнтэй холбоотой.

1. Филип яагаад өөрийнхөө найздаа өөрөө дөнгөж саяхан уулзсан Есүсийн тухай шууд ярихыг хүссэн бэ (ишлэл 43-45)?
  - Та Есүсийг мэдэхээр анх удаа ирсэн үеээ эргэн дурс. Та олж авсан зүйлээ бусдад хэлэхийг хүссэн үү? Яагаад гэдгээ тайлбарлна уу.
2. Юу Натанаелыг Филипийн үгэнд эргэлзэхэд хүргэсэн бэ?
  - Хэдий тийм ч Натанаел яагаад Есүсийг харахаар явсан бэ?
3. Есүс Натанаелтай мэндчилсэн үгсээрээ юуг илэрхийлсэн бэ?
  - Натанаел Есүсийн мэндчилхийг сонсоод хэрхэн хүлээн авсан гэж та бодож байна вэ?
  - Хэрэв Есүс өнөөдөр танд: "Энэ бол жинхэнэ Христчин хүн, түүний дотор худал байхгүй" гэж хэлсэн бол та хэрхэн хүлээн авах вэ?
4. Натанаел инжрийн модон доорх тохиолдсон зүйлийг Есүс мэдсэн гэдгийг сонсоод үнэхээр гайхсан байлаа. Натанаелийн тэнд юуг бодсон эсвэл залбирсаныг янз бүрийн боломжоор бодож үз.
5. Та саяхан ганцаараа байхдаа бодсон зүйлээ эргэн дурс. Есүс тэнд байсан бөгөөд таны бодлыг нээлттэй ном шиг уншсан гэдгийг та ойлгосны дараагаар энэ бүхнийг хэрхэн хүлээн авах вэ?
  - Зарим хүмүүс өөрийнхөө жинхэнэ "би"-г олж хардаг гэдэг нь хүн төрлөхтний хувьд ямар утгатай вэ?
6. Ишлэл 47 дахь Есүсийн үг нь тойруугаар Дуулал 32:1-2- ыг иш татдаг (Удирдагч тэдгээр ишлэлүүдийг уншиж болно). Тэдгээр ишлэлийн дагуу хүн яаж зүрхэндээ худалгүй тийм шудрага болж чаддаг вэ?
7. Натанаел ямар үндсэн дээр гэнэт Есүсийг Бурханы Хүү, Израйлын Хаан гэж дуудав (Ишлэл 49)?
8. Удирдагч Эхлэл 28:10-22-ыг энд дүгнэж болно. Есүс ишлэл 50-51-ээр юуг илэрхийлдэг вэ? Янз бүрийн боломжуудыг бод.
  - Иакобын шат Есүсийн загалмаатай юугаараа адил вэ?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

### 3. УС ДАРС БОЛСОН НЬ (Иохан 2:1-11)

**БЭЛТГЭЛ:** Хурим хийх нь Есүсийн цаг үед агуу үйл явдал байжээ. Энэ нь голдуу хэдэн өдөр үргэлжилдэг байв. Назар ба Канагийн хооронд шулуун замаар 12 километр зайтай байсан. Есүсийн эх хүүгийнхээ анхны гайхамшгийг хараахан хараагүй байсан. Гэвч тэр эмэгтэй өөрөө онгон төрөлтийн гайхамшгийг мэдэрсэн.

1. Хуримын найран дээр дарс нь дууссан шалтгаан нь юу байж болох вэ? Янз бүрийн боломжуудыг бод.
  - Энэ нөхцөлд гэрийн эзэн эсвэл залуу хосын санааг хамгийн их зовоож байсан зүйл юу гэж та бодож байна вэ?
2. Марийг энэ хуриман дээр тохиолдсон шиг ийм гайхамшигт бэлтгэгдсэн байсан гэж та бодож байна уу?
  - Ишлэл гурав Марийн Есүст хандсан залбирлыг агуулдаг. Та үүнтэй өөрийн залбиралыг харьцуулаад ялгаатай байгаа зүйлийг нь хар.
3. Есүс Марийн зөвлөлгөөг дагахаас татгалзахад яагаад тэр бууж өгөөгүй вэ?
  - Мариа яагаад энэ зүйлд өөрийн хүүд итгэсэн бэ?
  - Тэр анхандаа үүнийг хийх санаагүй байсан байж магадгүй. Гэвч яагаад Есүс энэ гайхамшгийг үйлдсэн бэ?

4. Мариагийнх шиг итгэл бидэнд ямар нөхцөл байдалд хэрэгтэй болдог вэ?
5. Зарц нар хөл үймээнтэй найр хуримын дундуур тосгоны худгаас хэдэн зуун литр ус зөөх болсонд ямар сэтгэгдэлтэй байсан бол?
  - Зарц нар яагаад Есүсийн хэлсэнээр үйлдсэн бэ?
6. Үнэхээрийн сайн дарс хийхийн тулд хэдэн жил шаардагдах вэ?
  - Ийм их хэмжээний дарс өнөө үед ямар үнэтэй болох вэ?
7. Та зарц нар ус дарсаар солигдсоныг мэдэхдээ хэрхэн хүлээн авсан гэж боддог вэ?
  - Та тэдгээр зарц нар энэ зүйлээс болж Есүст итгэсэн гэж боддог уу? Өөрийн тайлбарыг өг.
8. Библид “алдар” гэсэн үг нь бидний нүдэнд илэрхий харагддаг Бурханы оршихуйг илэрхийлдэг. Бурханы алдар эхлээд Майхан сүм болон Сүмд илчлэгдсэн. Есүс өөрийн шавь нартаа энэ тэмдгээр алдраа илчилсэн нь ямар утгатай вэ (ишлэл 11)?
  - Иохан яагаад өөрийн Сайн Мэдээндээ гайхамшгуудыг гайхамшгууд гэж нэрлэхийг хүсэлгүй тэмдгүүд гэж нэрлэв?
  - Иохан сүүлд нь бидэнд Бурханы алдар бас Есүсийн зовлонд илчлэгдсэн гэдгийг хэлдэг. Энэ нь юу гэсэн утгатай вэ?
9. Шавь нар нь энэ тэмдгийн дараа Есүсийн юунд итгэв?  
Яагаад шавь нарын итгэл хараахан бэлэн бус байсан бэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Хуучин Гэрээнд дарс нь Иудагаас гарах удирдагчтай холбогддог байв. “Шилог иртэл хааны таяг Иудагаас салахгүй.....Хувцсаа дарсанд, нөмрөгөө усан үзмийн шүүсэнд угаана....” (Эхлэл 49:10-11). Шинэ Гэрээнд дарс бидний нүглүүдийн төлөө урсгасан Есүсийн цустай холбоотой.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 4. ЕСҮС БА ШИЛБҮҮР (Иохан 2:13-22)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Иудейчуудын хувьд сүм нь дэлхийд хамгийн чухал, бүр тэдний гэр орноос ч илүү чухал байсан. Соломон хаан анхны сүмийг, хоёрдохыг нь Езра барьсан. Есүсийн цаг үеийн сүм нь Агуу Херод хаанаар сэргээгдэн баригдсан сүр жавхлант барилга байсан. Есүсийг цовдлогдсоны дараа энэ нь Иерусалимд ердөө гучаас дөчин жил л оршсон.

1. Ишлэл 14-16 унш. Есүсийн гаргасан зан чанараас юу нь таны гайхшралыг төрүүлж байна вэ?
  - Дээсээр шилбүүр хийхэд цаг хугцаа шаардлагатай болдог. Есүс энэ ажлыг хийх зуураа хэрхэн харагдсан гэж бодож байна вэ (ишлэл 15)?
  - Ишлэл 15-д тодорхойлсон тэр агшинд сүмд ямар хэрүүл шуугиан сонсогдож байсныг төсөөл.
2. Есүсийг ширээнүүдийг хөмрөн, ташуураа эргүүлж байхад яагаад хэн ч үүнийг зогсоохыг оролдоогүй вэ?
  - Есүс чухамдаа яг юунд ийнхүү их дургүй нь хүрэв?
3. Бидний энэ цаг үед ч бас Бурханы сүм / цуглаан худалдааны газар болж болно гэж та боддог уу? Өөрийн тайлбарыг өг.
  - Сүмд өргөгдсөн өргөлүүд нь тэдний өөрсдийн нүглүүдийг уучлуулахын тулд өргөдөг өргөл байв. Бурханы зорилгыг хангаагүй энэ тогтолцоо нь хэрхэн хахуульд баригдсан байв?
4. Зөвхөн гаднах үзэмжийн төлөө хийгдэг тэрхүү ёслолуудыг Библийн Бурхан яагаад үзэн яддаг вэ?
  - Хэрэв та өөрийн хувийн мөргөл, залбирал үйчлэл зэргийг тунгаан бодвол зөвхөн гадна үзэмжийн төлөө зүйл хэр их байдаг вэ?
  - Таны зүрх сэтгэлд дахь сүмыг сорьдог ямар зүйлсийг та өнөөдөр Христээр цэвэрлүүлэх ёстой вэ? (Та үүнийг өөрөөсөө асууж болно)

5. Есүсийн уур ба бидний уурын хооронд ямар ялгаа байдаг вэ (ишлэл 16-17)?

6. Энэ хэсэгт Есүс Өөрийн бие ба сүмийг хооронд нь адилтган дүрсэлсэн (ишлэл 19-21). Бурхан яагаад энэ дэлхийд өөр сүмийг босгох ёстой болсон бэ? (Есүс загалмайд өлгөгдөхдөө өөрийн цусаараа сүмийн ямар үүргийг биелүүлсэн бэ?)

7. Бурхан Христийн загалмайд цовдлогдоноос гуч эсвэл дөчин жилийн дараа Херодын сүмийг Ромчуудаар устгуулахыг яагаад зөвшөөрөх болсон талаарх янз бүрийн шалтгаануудыг бод. (Яагаад Иерусалимд сүм ямар ч шаардлаггүй болсон бэ?)

8. Христийн биеийн дүрслэл сүм учир зөвхөн түүний загалмай дээрх өргөлтэй холбоотой төдийгүй, түүнчлэн түүний дэлхий дээрх сүм, Христэд итгэгчдийн цуглаантай холбоотой (1 Коринт 12:27). Есүс Иерусалем сүмийг шуугиулсан шиг тиймэрхүү шинэчлэл өнөөдрийн цуглаанд хэрэгтэй гэж боддог уу? Өөрийн тайлбарыг өг.

- Цуглааны удирдагч ямар нөхцөлүүдэд шилбүүр эргүүлэх ёстой вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс таны төлөө, таны нүглүүдийн эвлэрүүлэлийн сүм болсон. Тэр зөвхөн сүм төдийгүй мөн өргөл юм: Ертөнцийн нүглийг үүрсэн Бурханы Хурга.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## **5. ФАРИСАЙ БА ХҮРЭЛ МОГОЙ (Иохан 3:1-16)**

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Никодем хэдийгээр шашныхаа хэргүүдэд мэргэжлийн гэж нэрлэгддэг боловч Тэр Бурханы хаанчлалд ороогүй. Үүнийг ойлгож мөн харж чадахгүй. Никодемд түүнээс залуу, нийгмийн байр суурь ба боловсролоороо өөрөөс нь илүү биш Есүстэй эдгээр асуудлуудыг хэлэлцэхээр ирэх нь хачирхалтай мэт санагддаг. Никодем бол Израйлын Санхендрины гишүүн байв.

1. Таны харснаар энэ сэдэвт Никодемийн зан чанарын сул ба хүчтэй тал нь юу вэ?(Никодем өдрөөр бус шөнөөр Есүстэй уулзахаар ирсэн. Энэ нь Никодемийн ямар талыг харуулдаг вэ?)

- Никодем Есүстэй юуны тухай ярихаар ирсэн бэ?

2. Никодем Бурханд бүх амьдралаараа итгэсэн байсан ч яагаад ямар ч авралын баталгаагүй байв?

- Бид ямар шалтгаануудаас болж авралын баталгаагүй байж болох вэ?

3. Дараа нь бид Есүсийн энд хэрэглэдэг “дахин төрөх” гэсэн хэллэгийг авч үзье. Хэн нэгэн нь дахин төрөхөд ямар өөрчлөлт гарах вэ (ишлэл 3-8)?

- Тэр “ус болон Сүнсээр” төрөх ёстой гэсэн нь ямар утгыг илэрхийлсэн байж болох вэ? (ишлэл 5)

4. Никодем Есүсээс “Ийм юм (дахин төрөх) яаж болдог юм бэ?” гэж асуудаг (ишлэл 9). Есүс түүнд ямар хариу өгсөнийг өөрийн үгээр тайлбарла (ишлэл 10-16).

5. Есүс шинэ төрөлтийг тайлбарлахдаа Израйлийн цөл дэх аяллын нэг жишээг авсан. Энэ нь Бурхан өөрийн хүмүүсийн нүглийг шийтгэхийн тулд хорт могойг илгээсэн үйл явдал байв. Хэдий тиймч Бурхан эцэст нь энэ хорны эсрэг ерөндгийг өгсөн: Мосегийн өргөсөн хүрэл могойг харсан хүн бүр аврагдсан (Тооллого 21:4-9). Энэ үйл явдал юугаараа Есүсийн загалмай дээрх үхэлтэй адил байдаг вэ? Аль болох олон адилхан зүйлүүдийг ол.

6. Хүрэл могойг харахаар шийдсэн хүмүүс юунд итгэсэн бэ?

- Библи бидэнд тэр өдөр маш олон хүмүүс үхсэн гэдгийг хэлдэг. Яагаад Бурханы бэтгэсэн ерөндөгт хүн бүр итгээгүй вэ?
- Хуучин Гэрээний энэ үйл явдал нь дахин төрөхтэй ямар холбоотой вэ?

7. Библид могой бол ихэнхдээ Бурханы дайсан Сатаны тэмдэг болон илэрхийлэгддэг. Энэ тохиолдолд Есүс яагаад Өөрийгөө болон могойг хооронд нь адилтган дүрсэлсэн гэж та боддог вэ?

8. Ишлэл 16 бидэнд дахин төрөх талаар юуг заадаг вэ?

9. (Хэрэв ямар нэг хугацаа үлдсэн бол) Танд шинэ төрөлтийн талаар ямар буруу ойлголтууд байсан бэ? Тэдгээрийн энэ сэдвийн санааны дагуу хэлэлц.

**БАЯРТ МЭДЭЭ:** Бурхан таныг маш их хайрлан цорын ганц Хүүгээ өгсөн, тиймээс та түүнд итгэхийг хүсвэл та мөхөхгүй, харин мөнх амьтай болно.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 6. АМИЙН УС (Иохан 4:5-19)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Самаричууд цус холилдсон хүмүүс байсан тул Иудейчууд тэднийг гадуурхдаг байв. Хэрэв тэр үед энэ эмэгтэй дөнгөж гуч орчим настай байсан бол энэ нь тэр эмэгтэй бараг 2 жил бүр өөрийн хамтран амьдрагч эрэгтэйгээ солидог байсныг илэрхийлж байна.

1. Самарын бусад эмэгтэйчүүд нар жаргах үед ус авдаг заншилтай байсан атал энэ эмэгтэй яагаад жин үдээр ус авахаар явсан гэж та боддог вэ? (Та энэ эмэгтэй өдөр бүр худаг уруу ганцаараа явахдаа юуг мэдэрсэн гэж боддог вэ?)

- Энэ эмэгтэй хэнтэй хамт явж болох байсан бэ?
- Та тэр эмэгтэйд ирээдүйн талаар ямар найдвар ба айдас байсан гэж боддог вэ?

2. Таван хайрлагчаа дараалан хаях эсвэл таван удаа хаягдахын аль нь хэцүү вэ? Өөрийн тайлбараа өг.

- Түүнийг зургаа дахь харилцаагаа гэрэлсэн эхнэртэй хүнтэй эхлэхэд түүнд ямар байсан гэж та боддог вэ?
- Тэр эмэгтэй тосгоны зарим хүүхдүүдийн эцгийг булааж авсангаа хэрхэн зөвтгөж болох байсан бол?

3. Та тэр эмэгтэй өөрийнхөө болон эрцүүд мөнх хайрын талаар юуг мэдэрсэн бол?

4. Иудей хүмүүс эмэгтэйчүүдтэй олон нийтийн газар ярилцахаас зайлсхийдэг бөгөөд ялангуяа ганц ганцаараа ийнхүү уулздаггүй байв. Есүс яагаад шүүмжлэл ба цуурхалаас айхгүй байв?

- Есүс яриагаа яагаад түүнээс тусламж хүссэнээр эхлэв (ишлэл 7)?

5. Эмэгтэй ишлэл 10 дахь Есүсийн үгсийг ямар байдлаар буруу ойлгосон бэ?

- Энэ эмэгтэй юугаар цангаж байсан бэ?
- Та өөрийн амьдралдаа юугаар хамгийн их цангадаг вэ?

6. Ишлэл 14 дэх үгсийг унш Есүсийн танд хувьчилан хэлж байга мэт унш. Эдгээр үгс нь таны одоогийн нөхцөл байдалд ямар утгатай вэ?

- Зүрх сэтгэлдээ амийн худгийн устай хүн яг ямар байдаг вэ?

7. Есүс яагаад эмэгтэйн шаардлагад: "Явж, нөхрөө дуудаад энд ир." гэж хэлснээр хариулдаг вэ (ишлэл 15-16)?

- Хэрэв Есүс ишлэл 16-17 дахь үгсээ хэлэлгүйгээр ишлэл 18-ыг эмэгтэйд тунхагласан бол юу болох байв?
- Бидэнд амийн усыг өгөхөөс өмнө Есүс яагаад бидний нүглүүдийг харуулдаг вэ?

8. Есүс түүний бүхий л амьдралын түүхийг нь мэддэг гэдгийг ойлгоод тэр эмэгтэй юу мэдэрсэн бол?

- Есүс түүнийг үзэн ядахын оронд харин түүнд анхаарал тавьсаныг хэрхэн ойлгосон бэ?

9. Есүс үнэндээ Мессиа байснаа бусдаас нууж байсан. Гэвч энэ эмэгтэйд илчилсэн. Тэр яагаад ийнхүү өөрийгөө илчлэх болсон бэ? (ишлэл 25-26)

10. Ишлэл 28-30-ыг ажигла. Тэр эмэгтэй Есүсээс амийн усийг хүлээн авсан нь түүний амьдралд ямар бодит үр дагавар авчирсан бэ? (Тэр эмэгтэйн өөрийн нүглүүдэд хандах хандлага нь хэрхэн өөрчлөгдсөн бэ?) Тэр эмэгтэйн тосгонынхонтойгоо харилцах харилцаа нь ямар болсон бэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс загалмай дээр: “Би цангаж байна.” гэж хашгирсан (Иохан 19:28). Амийн усны худгийг эзэмшигч нь энэ бие ба сүнсний цангах зовлонг мэдрэх ёстой болсон. Энэ нь Түүний өнөөдрийг хүртэл бидэнд өгч байгаа амийн усны төлөө төлөгдөх ёстой болсон юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 7. ТЭМДЭГҮҮД, ГАЙХАМШГУУД БА ИТГЭЛ (Иохан 4:46-54)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Энэ хэсэгт Есүсийг хайдаг түшмэл Херод Антипийн төлөө ажиллаж байсан. Тэр бол Баптист Иоханыг баривчилж, алсан хүн байсан. (Бетлехемийн нялх хүүхдүүдийг алсан Херод түүний өвөө нь байсан.) Херодууд бол хагас Иудей бөгөөд Иудейчуудад хамгийн нэр хүндгүй хүмүүс байсан. Кафернум ба Кана хотын хооронд 38 Километр зайтай.

1. Хүү нь өвдөхөөс өмнө энэ хааны түшмэлийн амьдралд байсан сайн ба муу зүйлүүд нь юу байсан гэж та бодож байна?
2. Энэ түшмэл яагаад Есүс рүү өөрийн зарц нараа явуулалгүй өөрөө явахаар шийдсэнийн бэ?
  - Яг таны байгаа газраас 40 өөд километрийн цаана байдаг ямар нэгэн газрын талаар бод. Энэ эцэг Кана уруу тийм урт зам туулахдаа юу бодож байсан байж болох вэ?
3. Есүсээс тусламж хүсэх нь энэ хүнд яагаад хэцүү байв?
  - Есүст ойртоход танд хэцүү байсан үеэ эргэн дурс. Яагаад тийм хэцүү байсан бэ?
4. Ишлэл 48-дахь Есүсийн үгс энэ түүхийн үргэлжлэлтэй ямар холбоотой вэ?
  - Итгэхийн тулд тэмдгүүд ба гайхамшгуудыг хайдагт ямар буруу байна вэ?
  - Таны бодлоор бол энэ хүнд ишлэл 48 дах Есүсийн үгийг хэрэглэх боломжтой юу?
5. Энэ хүн Есүсээс түүнтэй хамт Капернаум явахыг гуйхад тэр яагаад яваагүй вэ?
  - Есүстэй уулзсанаар түүний итгэл хэрхэн өөрчлөгдөв?
6. Түүний тусламжийг мэдрэхээс өмнө Бурханы үгэнд энгийнээр итгэх нь яагаад тийм хэцүү байдаг вэ?
  - Ийм чухал мөчид таны бат зуурах ёстой Бурханы ямар амлалт байдаг вэ?
7. Хүүгийн эдгэрэлийн агшин яагаад бидний төлөө Библид тэмдэглэгдсэн бэ (ишлэл 52)?
  - Хэрэв хүүхэд нь Есүсийг амлалт өгөх үед биш харин өөр цагт эдгэрсэн бол эцэгийн хувьд энэ нь ямар ялгаатай байх байсан бэ?
8. Энэ хэсгийн дагуу “итгэл” нь ямар утгатай вэ?
  - Өөрийн итгэлийг энэхүү эцгийн итгэлтэй харьцуул.
9. Энэ үйл явдал Есүсийн үгийн талаар бидэнд юу заадаг вэ?
  - Бурханы үггүйгээр зовох эсвэл зовох үедээ Түүний амлалтуудаас бат зуурах хоёрын хооронд ямар ялгаа байх вэ?
10. Есүс үхэлд ойр байхдаа яагаад Өөрийн үгийн хүч чадлыг хэрэглээгүй вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүсийн үг маш их хүч чадалтай. Учир нь Тэр үүний төлөө маш их үнэ төлсөн: Хааны түшмэлийн хүү амьдарсан, харин Бурханын Хүү оронд нь нас барсан.

## 8. ХҮН БҮРТ ХАЯГДСАН НЬ (Иохан 5:1-18)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Энэ хэсэг Саббат өдрийн талаарх Есүс ба Иудейчуудын анхны маргааны тухай дурддаг. Иудейчуудын хувьд Саббат өдөр нь амралтын ариун өдөр байсан. Тэдний итгэлийн дагуу бүх үндэстэн нэг Саббат өдөртэй болох хүртэл Мессая ирэхгүй юм. Иерусалим дахь Архилогийн малтлагуудаас Бетзада цөөрмийг багануудынх нь хамт илрүүлсэн.

- 38 жилийн турш Бетзадагийн баганы дор байсан энэ хүн ямар амьдралтай байсныг нь төсөөл.
  - Ишлэл 5 дахь астенеиа гэсэн Грек үг нь өвчтэй гэсэн утгыг илэрхийлж болно, гэвч энэ нь ихэнхдээ "сул дорой" гэсэн ганц утгатай байдаг. Үүнийг хоёр талаас нь өөр өөрөөр бодож үз. Энэ хүний зовлон юу байсан бэ?
  - Эхний 10 жилийн өвчлөлт нь сүүлийн арван жилийнхээс өөр байж болох уу?
- Яагаад төрөл төрөгсөд нь түүнийг халамжлаагүй вэ (ишлэл 7)? (Түүний өөрийн алдаанаас болсон зүйл юу байж болох вэ? Бусдын алдаанаас болсон зүйл юу байж болох вэ?)
  - Энэ хүний зан чанарын талаар танд ямар сэтгэгдэл төрдөг вэ? Түүний үгсийг ишлэл 7-гоос ажигла.
- Өвчтэй болоод эдгэрлийг хүлээж байгаа хүмүүсийн хоорондын харилцаа ямар байсан бол?
  - Хэдийгээр тэр бусдаасаа илүү удаан тэнд байсан боловч тэд яагаад түүнийг эхэнд оруулаагүй вэ?
- Энэ хүний итгэлийн тусгал нь үнэндээ юу байв? (Тэр хаанаас тусламж олно гэж найдаж байсан бэ?)
  - Бидний өнөө үед өвчтэй хүмүүсийг найддаг" ямар гайхамшигтай "эмчилгээ" байдаг вэ?
  - Есүсийн ишлэл 14-д дурдсанаар энэ хүнд ямар нүгэл байв?
- Есүс яагаад өөр шаналагчид бус энэ хүнд онцгойлон ойртохоор шийдсэн гэж та боддог вэ?
  - Яагаад Есүс энэ хүнээс хариулт нь илэрхий асуулт асуусан бэ (ишлэл 6)?
  - Яагаад энэ хүн Есүсийн асуултанд тодорхой хариулаагүй бэ (ишлэл 7)?
  - Хэрэв Есүс одоо таныг зарим бэрхшээлтэй асуудлаа шийдэхийг хүсэж байгаа эсэхийг тань асуувал та юу гэж хариулах вэ?
- Есүсийн үзлээр, гучин найман жилийн зовлонгоос илүү муу зүйл юу вэ? (ишлэл 14)
  - Есүсийн үзлээр, танд одоо байгаа зовлонгоос илүү муу зүйл нь юу вэ?
- Тэр хүн эдгэрснийхээ дараа ямар зорилгоор сүмд очсон гэж та бодож байна вэ? (ишлэл 14)
  - Энэ хүн Есүст хэзээ итгэсэн бэ? (хэрэв тэр хаа нэгтээ итгэсэн бол)
- Энэ хүн яагаад ишлэл 15 дахь зүйлийг үйлдсэн бэ? Янз бүрийн боломжийн тайлбаруудыг ол.
  - Есүс энэ үйл явдлыг хэрхэн төгсөхийг урьдчилан мэдэж байсан нь лавтай. Тэгээд яагаад Тэрээр тэрхүү хүнийг эдгээв?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс эцэстээ энэ сэдэвт гарсан хүний адил тавиланг үүрэх ёстой байв: Есүс гучин найман жил өвчилсөн хүнээс илүү хүнд зовлонг амсах ёстой болсон: Түүнийг тэнгэрлэг Эцэг нь орхисон. Энэ нь Түүнийг одоо хаягдсан хэн нэгэнд: "Таныг харж хандах нэгэн танд бий. Танд би байна!" гэж хэлэх чадвартай байдгийн шалтгаан юм.

## 9. АМИЙН ТАЛХ (Иохан 6:1-15)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Хүмүүсийн ишлэл 14-д ярьж байгаа эш үзүүлэгч нь Мосегын дэлхий дээр ирнэ хэмээн тунхаглаж байсан нэгэн юм. Тэр эш үзүүлэгчийг Мосе өөртөөгөө адил байх гэж таамагласан (Дэд Хууль 18:15 ба18). Учир нь хүмүүс Мосегын үед цөлд маннаг хүлээн авсан бөгөөд энэ шинэ зөнч түүнтэй адил гайхамшигийг хийх чадвартай байв. Тэр үед таван жижиг талх, хоёр загасаар нэг хоол хийдэг байв.

1. Есүсийн нэр алдаршсаны нууц нь юу вэ? (ишлэл 2)
  - Яагаад Есүсийн алдаршилт удаан үргэлжлээгүй вэ?
  - Алдартай хүмүүс нэр хүнд нь буурахад голдуу юу хийдэг вэ?
2. Есүс яагаад дахин дахин шавь нарынхаа итгэлийг шалгав (ишлэл 5-6)?
  - Таны бодлоор шавь нар тэдгээр итгэлийн шалгалтуудаар илүү боловсорсон уу?
  - Бурхан таны итгэлийг санхүүгийн хэцүү асуудлаар хэрхэн шалгасан вэ? (Та өөрөө зүрх сэтгэлдээ хариулж болно.)
3. 200 денар Есүсийн өдрүүдэд найман сарын ажлын хөлстэй дүйцэж байв. Өнөөдрийн манай оронд та найман сарынхаа ажлын хөлсөөр хэр олон хүмүүсийг хоолож чадах вэ (ишлэл 7)?
4. Та тэр хүүхэд өдрийнхөө хоолыг шавь нарын нэгэнд өгөхдөө юуг мэдэрсэн гэж боддог вэ (ишлэл 9)?
  - Томас Есүст хүүхдийн талаар дурдахдаа ямар нэгэн гайхамшиг болно гэж хүлээж байсан болов уу? Өөрийн тайлбараа өг.
5. Зарим теологчид тэр хоол 5000 дахин өссөн, учир нь тэдэнд идэх юм байсан бөгөөд түүнийгээ тэд өөрсдийнхөө хөрштэйгөө хуваасан гэж маргадаг. Энэ хэсэгт яг юу энэ тайлбар буруу гэдгийг харуулж байна вэ?
  - Бүх дөрвөн сайн мэдээнд тэмдэглэгдсэн энэ гайхамшиг яагаад тийм чухал байдаг вэ?
6. Бүхий л түүхийн турш хүмүүс ямар төрлийн удирдагчийг сонгосон бэ (ишлэл 15)?
  - Есүс тэр үед Давидын удам гэдгээ баталсан хэдий ч Тэр үед хүмүүс яагаад Түүнийг Иүдэйчүүдийн хаан болгохыг хүсээгүй вэ?
7. Өнөөдөр “хүмүүс” Есүсээс юуг хамгаас илүү авахыг боддог вэ?
  - Та өнөөдөр Есүсээс юуг хамгаас илүүгээр авахыг хүсдэг вэ?
  - Есүсийн хооллолтын гайхамшиг нь өнөөдөр танд юуг хэлдэг вэ?
8. Яагаад хүмүүс энэ онцгой гайхамшигийг амссаны дараа ч Есүсээс гайхамшигийн тэмдгүүдийг шаардсаар байсан бэ (ишлэл 30)?
9. Есүс энэ гайхамшигийн дараа өөрийгөө амийн талх гэдгээ хэлснээр юуг илэрхийлсэн бэ (ишлэл 35)?

**БАЯРТ МЭДЭЭ:** Ишлэл 48-51 унш. 5000 хүнийг хооллосон гайхамшиг нь Есүсийн Өөрийнх нь тухай-Түүнийг хэрхэн амийн талх болсон тухай өгүүлдэг. Есүс үхэх ёстой байсан нь бид түүний амийн талхыг идэж мөн амьдрахын тулд байв. Түүнчлэн амийн талх нь Ариун Зоогын талхийг ч илэрхийлж болно.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 10. НУУЦЛАГДСАН МЕССИА (Иохан 7:40-52)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Ишлэл 40-д мянган жилээс илүүтэй найдан хүлээсэн Иудейчуудад илэрсэн эш үзүүлэгч шинэ Мосег дахин дурддаг (Дэд Хууль 18:15, 18).

1. Энэ сэдэвт ямар өөр өөр бүлгийн хүмүүс илэрдэг вэ?
  - Тэдгээр хүмүүс Есүсийн эсрэг ямар өөр өөр байр суурийг баримтладаг вэ?
2. Есүсийн үеийнхэн Түүнийг Мессиа мөн гэдгийг ямар үндэслэлээр ойлгох ёстой байсан бэ?
  - Яагаад Есүс хүн бүрт: "Би Назарт өссөн, гэвч Би бол Бетлехемд төрсөн Давидын удам." гэж хэлээгүй вэ?
3. Есүс бол Мессиа гэдэгт итгэх нь Түүнийг дэлхийд байсан үеээс одоо үед илүү хялбар уу? Өөрийн тайлбарыг өг.
4. Есүс яагаад Мессиа гэдгээ нууцлах ёстой болов? (Хэрэв Есүс Мессиа гэдгээ эхнээсээ л илэрхий болгосон бол юу тохиолдох байв?)
5. Ямар зүйл нь хүнийг бүлгэлсэн хүчний эсрэг зогсоход хүндрэл учруулдаг вэ? (ишлэл 45-48)?
6. Ишлэл 49 бидэнд Фарисайчуудын ямарваа нэгн зүйлийг эрэгцүүлэн бодох аргын талаар юуг илчилсэн бэ?
7. Ишлэл 45-52-д тодорхойлсоны дагуу бол Фарисайчууд зөвлөлийн хуралд анх юу хийхээр төлөвлөсөн байж болох вэ?
  - Яагаад сүмийн харгалзагчидад Есүсийн үгс гайхамшгуудаас нь илүү сэтгэгдэл төрүүлж чадсан бэ?
8. Хэрэв Никодем чимээгүй байсан бол юу болох байсан бол (Ишлэл 50-51)?
  - Өмнө нь Никодем Есүс рүү шөнөөр ирсэн нь бусад Фарисайчуудаас эмээснийх байсан байх. Тэр яагаад гэнэт санаандаа хадгалснаа хэлэх зоригтой болсон бэ?
  - Түүнчлэн хүн бүр тантай санал зөрсөн ч танд өөрийн итгэлээ илэрхийлэх зориг байдаг уу?
9. Таны бодлоор, Никодемийн үг тэдний хүссэн зүйлд нөлөөлсөн үү? Хэрэв тэдэнд нөлөөсөн бол энэ нь ямар нөлөө байсан бэ?
  - Бусдын хатуу шүүмжлэлээр төгсөхөд Никодем хэлсэн зүйлдээ харамссан уу (ишлэл 52)?
 Өөрийн тайлбарыг өг.
10. (Хэрэв хугацаа байвал) Эрх мэдэлтнүүд буруу шийд гаргаж байгаа нөхцөлд та хувь хүний хувьд ямар хариуцлагатай вэ?
  - Бурхан яагаад хүн бүрийн өмнө Мессиа гэдгээ тодорхой илчлээгүй гэж та боддог вэ?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 11. ЕСҮС ШҮҮСЭН НЬ (Иохан 8:1-11)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Мосегийн Хуулийн дагуу садар самуунаар баригдсан эрэгтэй ба эмэгтэйг хамт чулуудаж алах ёстой байв (Левит 20:10). Хэдий тиймч Израйлыг эзэлсэн Ромчууд цаазаар авах шийтгэлд тэргүүлэх эрх мэдэлтэй байв.

1. Ямар зүйл хүнийг садар самуун үйлдэлд хүргэдэг вэ? Янз бүрийн хариултуудыг бод.
  - Энэ эмэгтэйн "шинэ хайрыг" хүлээн авсаны дараах амьдралыг нь төсөөл. Энэ харилцаа түүний амьдралд ямар аз жаргал, ямар шаналалыг авчирсан бэ?
2. Та садар самуун үйлдэгчийг үйлдэл дээр нь барихад хамгийн муу тал нь юу гэж боддог вэ?
  - Эрэгтэй явалдагч нь зугтсаны дараа тэр эмэгтэй түүний талаар юу мэдэрсэн гэж та боддог вэ?
  - Түүнчлэн гэрлэсэн байж болзошгүй эрэгтэйд энэ нөхцөлд хамгийн хэцүү зүйл нь юу байсан гэж та боддог вэ?
3. Энэ үйл явдалд олон хүн хамаарагдсан байсан. Дараах хүмүүс үхлээр шийтгүүлэх боломжтой

энэхүү садар самууныг үйлдэгчдийн талаар хэрхэн мэдэрснийг бод: эмэгтэйн нөхөр, хүүхдүүд, эцэг эх нь (хэрэв амьд байсан бол) мөн эрэгтэйн эхнэр, хүүхдүүд юу гэж бодох бол ?

- Энэ үйл явдал хүүхдүүдийнх нь ирээдүйд хэрхэн нөлөөлсөн байж болох вэ?

4. Тэр эмэгтэйг Есүсийн өмнө чирэгдэн очоод түүний талаар юу мэдэрсэн гэж та боддог вэ (ишлэл 3-5)?

- Та тэр эмэгтэйг тухайн үед садар самуун үйлдлийнхээ талаар юу гэж бодсон бол?

5. Иудейчууд үхлийн шийтгэлийг зөвхөн Ромчууд тэргүүлэн шийдэх зүйл гэдгийг мэдсэн хэдий ч тэр эмэгтэйг яагаад Есүсийн өмнө чирэн авчирсан бэ?

- Есүс маш энгийнээр: "Та нарын хэн ч энэ эмэгтэйг чулуугаар шидэх эрхгүй" хэмээн хариулахын оронд яагаад 7-р ишлэл дээр бичигдсэн зүйлийг хэлсэн бэ?

6. Тэдгээр буруутгагчид яагаад ишлэл 9-д бичигдсэн дарааллаар тэр газрыг орхин явцгаасан вэ?

- Есүс яагаад Өөрийнх нь үг сонсогчидод хэрхэн нөлөөлсөнийг ажиглалгүйгээр харин оронд нь газарт бөхийн юм бичсэн бэ?

7. Яагаад зөвхөн Есүс л ганцаараа тэр эмэгтэйг үхлийн шийтгэлээр яллах эрхтэй байв?

- Есүс энэ үед яагаад Мосегийн Хуулийн дагуу үйлдээгүй вэ?
- Олон хүмүүсийн аз жаргалыг бусниулсанийхаа төлөө авах ёстой байсан түүний шийтгэл нь юу болсон бэ?

8. Есүс хоёр дахь удаагаа газарт юм бичих үед энэ эмэгтэй боломжтой байсан боловч яагаад тэндээс зугтаагүй вэ? (ишлэл 8-9)

- Энэ эмэгтэй өөрийнх нь нүгэл уучлагдсан гэдэгт яг хэзээ итгэсэн гэж та бодож байна вэ?

9. Есүс яагаад ишлэл 11 дэх үгсийг энэ эмэгтэйд хэлсэн гэж та таамаглаж байна вэ?

- Түүнчлэн Есүс ишлэл 11 дэх үгсийг танд ч гэсэн хэлж байна. Тэдгээр нь өнөөдрийн нөхцөл байдалд танд юуг илэрхийлж байна вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүсийн газар дээр бичсэн зүйлсийг бидэнд дурдаагүй. Магадгүй тэр шүүгч шиг эхлээд садар самууныг сонордуулсан Хуулийн алах ялыг бичсэн байх. Хоёр дахь удаагаа газар бөхийхдөө Тэрээр: "Би түүний өмнөөс шийтгэлийг нь эдлэнэ." гэсэн үгсийг нэмж бичсэн ч байж болох юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 12. ЕРТӨНЦИЙН ГЭРЭЛ (Иохан 9:1-7, 18-23 ба 35-41)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Есүсийн төрөлхийн сохор хүнийг эдгээсэн гайхамшиг нь түүний бусад гайхамшгуудаас илүүгээр хүмүүсийн анхаарлыг татсан. (Иохан 9:32, 10:21, 11:37). Хэрэв хэн нэгэн төрөлхийн сохор бол түүний нүдний алим нь дутуу хөгжилтэй байдаг. Түүний оронд түүний бусад мэдрэмжүүд, жишээлбэл, сонсгол нь ихэнхдээ маш мэдрэмтгий болдог.

1. Ишлэл1-7

- Хэрэв гэр бүлд нь эрхтэн дутуу хүүхэд төрвөл эцэг эхийн нь амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ?
- Энэ нөхцөл байдалд тэдгээр эцэг эхийн хэрхэн энэ асуудалд хандсан талаарх таны бодол?
- Энэ сохор гуйлгачингийн жирийн өдөр ямар байхыг төсөөлөхийг оролд.
- Та энэ хүнийг Бурханы хайрын талаар юу бодож байсан гэж боддог вэ?
- Хажуугаар нь өнгөрч байгаа хүмүүс түүнийг эрхтэн дутуу гэж хэлснийг сохор гуйлгачин маш олон удаа сонссон байх. Хүн ер нь тэдгээр шавь нарынхтай адил тайлбаруудыг үргэлж сонсоод байх чадвартай гэж та боддог уу (ишлэл 2)?
- Яагаад хүмүүс бид эргэн тойрныхоо зовлонд хэн нэгнийг үргэлж буруушаахыг хүсдэг вэ?
- Та ямар нөхцөлд таны өөрийн болон гэр бүлийн зовлон тань өөр хүний буруугаас болсон гэж бодож байсан бэ?

- Шавь нарын асуултанд Есүсийн өгсөн хариултыг сонсоод тэрхүү сохор гуйлгачин юу гэж бодсон бэ? (ишлэл 3-5)
- Таны бодлоор, та өөрийнхөө амьдралаар Бурханы ажилыг харуулж болох хамгийн сайн арга зам юу вэ?
- Үл таних хүн ирээд нүдийг нь шавраар таглахад түүнийг эсэргүүцээгү энэхүү үйлдэл нь юуг харуулдаг вэ (ишлэл 6)?
- Есүс энэ сохор хүнийг яагаад шууд газар дээр нь эдгээлгүй харин түүнийг Силиомын цөөрөм рүү өөрөөр нь замаа тэнтчин явуулхаар шийдсэн бэ?

2. Ишлэл 18-23. Эцэг эхийн хариу үйлдэл. Синагогоос хөөгдвөл мөн олон нийтээсээ адил хөөгддөг байсан гэдгийг анхаар (хурим, оршуулга гэх мэт).

- Ишлэл 2-той адил тайлбар үгсийг сонсоод эцэг эх нь ямар хариу үйлдэл үзүүлэх байсан бол?
- Хүүгээ эдгэрсэнийг хараад эцэг эх нь яагаад баяртай байгаагүй мэт сэтгэгдэл төрүүлж байна вэ?
- Яагаад эдгээгдсэн хүү нь эцэг эхээсээ эсрэгээр Синагогаас хөөгдөхөөс айгаагүй вэ (ишлэл 22)?
- Та тэдгээр эцэг эхийн нөхцөл байдалд хэрхэн хандах байсан гэж боддог бэ?

3. Ишлэл 35-43. Есүс ба эдгэрсэн хүн хоёрын хоорондох хоёрдох учрал.

- Есүс яагаад энэ хүнтэй дахин нэг удаа уулзахыг хүссэн гэж та боддог вэ?
- Яагаад Есүс: “Чи хүний Хүүд итгэж байна уу?” гэж хэлэхийн оронд “Чи надад итгэж байна уу?” гэж асуугаагүй вэ (ишлэл 35)?
- Есүс үүнтэй адил асуултыг өнөөдөр танаас асууж байна. Та Түүнд юу гэж хариулах вэ?
- Есүс ертөнцийн гэрэл гэсэн нь ямар утгатай вэ (ишлэл 5)?
- Ишлэл 39 ямар утгатай вэ?
- Хэдийгээр Есүс Өөрөө ертөнцийн гэрэл байсан ч яагаад тамын харанхуйг туулах ёстой болсон гэж та боддог вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Таны болон таны хайрладаг хүмүүсийн зовлонгууд нь таны амьдралд Бурханы ажлыг харуулахын тулд өгөгдсөн юм. Ишлэл 3 өнөөдөр танд хувьчан зориулагдсан Есүсийн үг тул гэрийнхэндээ дамжуул.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 13. САЙН ХОНЬЧИН (Иохан 10:1-16)

1. Ишлэл 1-6. Энэ үед Есүс Өөрийнхөө тухай ярьж байна гэдгээ хараахан илчлээгүй байсан. Таны Библийн судалгаанд ийм маягын хэлэлцүүлгэ зөвхөн хоньчин ба түүний хоньдын тухай үгчлэн ярих мөч байх ёстой.

- Эдгээр зургаан ишлэлийн дагуу хонинд ямар онцлог шинжүүд байдаг вэ?
- Тэдгээр ишлэлүүдийн дагуу хоньчинд ямар онцлог шинж тэмдэгүүд байдаг вэ?
- Хоньчингүй хонь яагаад удирдлаггүй байдаг вэ?
- Нэг хоньчныг нөгөөгөөр нь солих яагаад амархан биш байдаг вэ?
- Хоньчин хулгайч хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ?
- Хонины амьдралд шөнийн манаач ямар үүрэгтэй вэ?

2. Ишлэл 7-10. Хулгайч нар, дээрэмчид ба хашааны үүд.

- Есүс бол үүд гэсэн нь ямар утгатай вэ? (Тэр хаана байх ёстой үүд вэ?)
- Есүс ишлэл наймд хэний тухай дурдаж байна вэ?
- Яагаад хэн нэг нь Христчин нөхөрлөл рүү хаалгаар нь биш харин хашаа давж орохыг хүснэ гэж?
- Христчин нөхөрлөл дотор “хулгайлаж, алж сүйтгэдэг” хүмүүс байдаг гэдгээ хэлснээрээ Есүс юуг илэрхийлэж байна вэ?
- Есүсийн хэлсэн эдгээр үгс таны өөрийн амьдралтай холбоотой юу: “Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн.” (ишлэл 10)?

3. Ишлэл 11-13. Энд Есүс Өөрийгөө Хуучин Гэрээнд олон зөнч нарын бичсэн тэрхүү Сайн Хоньчин гэдгээ илчилдэг (Жишээлбэл, Езекил 34 ба Дуулал 23).

- Хоньчин ба хөлсний хоньчингын хооронд ямар ялгаа байдаг вэ? ( Ямар шалтгаанаас болж энэ ажлыг хүлээн авах байсан гэж бодож байна вэ?)
- Есүс “хөлсний хоньчноор” хэнийг дурдаж байна вэ?
- Есүс ба сайн хоньчны хоорондын адил төстэй талуудыг ол.
- Хэрэв хүүхэд тань нохойныхоо төлөө өөрийн амийг өгвөл та хэрхэн хүлээн авах вэ?
- Танд: Хүний төлөө үхдэг Бурхан эсвэл амьтны төлөө үхдэг хүн гэсэн эдгээр хоёр зүйлийн аль нь илүү утга учиртай вэ?
- Яагаад Есүс таны төлөө ихэхийг зөвшөөрсөн бэ?
- Христчин хүмүүсийн дунд байдаг “чононы” тухай жишээг өг.
- өнөөгийн хоньчид яаж Христчин нөхөрлөл рүү довтолж буй чонотой тэмцэлдэх ёстой вэ?

4. Ишлэл 14-16. Сайн хоньчныг мэдэх нь.

- Хонь ба хоньчин нь бие биеэ хэрхэн мэддэг вэ? (Есүс биднийг, бид Түүнийг хэрхэн мэдэх вэ?)
- Энэ хэсэг бидэнд Есүсийн үгний талаар юуг зааж байна вэ (3, 4, 5, 8, 16)?
- Бид Есүсийн дууг бусдын дуунаас хэрхэн ялгаж сурах вэ?
- Дэлхийн бүх Христэд итгэгчдэд нийтлэг ямар зүйл байдаг вэ (ишлэл16)?
- Яагаад бид Түүний үхлийнх нь талаар ярилгүйгээр Сайн Хоньчины талаар ярьж чадахгүй вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Библи уншигч нь Эгиптээс гарсан нь 12:7,13 уншиж өг. Энэ сэдэв хонь ба хонины үүдний төсөөллийг хамтад нь холбодог бөгөөд бидэнд Есүс Өөрөө хэрхэн үүд болсоныг заадаг.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 14. АМЬ БА АМИЛАЛТ (Иохан 11:1-5 ба 32-460)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Есүс Лазарыг өвчилсөн тухай сонсох үед Бетанаас нэг өдрийн зайтай хол байсан.

Ишлэл 1-5

1. Тэдгээр гурван эгч дүүс Есүс тэднийг хайрласан гэдгийг хэрхэн мэдсэн бэ? (ишлэл 3 ба 5)
- Есүс таныг болон гэр бүлийг тань хайрлдаг гэдгийг хэрхэн мэдэж болох вэ?

2. Есүс яагаад тэр даруйдаа Лазарыг эдгээхийн тулд яваагүй вэ?

- Есүс ишлэл 4 дэх үгсээр юуг илэрхийлсэн бэ?
- Есүс ишлэл 4 дэхь үгээрээ таны зовлонгийн тухай бас хэлсэн гэж та боддог уу?

Ишлэл 25-26

3. Эдгээр ишлэл юуг илэрхийлдэг вэ?

- Яагаад Есүс итгэдэг хин үхлээс айх хэрэггүй байдаг вэ?

Ишлэл 32-46

4. Есүс ишлэл 32 дахь үгийг хэлэх үед Марь Түүний талаар хэрхэн мэдэрсэн гэж та боддог вэ? Янз бүрийн боломжуудыг хэлэлц.

5. Есүсийн “сүнс нь гүнээ шаналж, сэтгэл нь хөдлөсөн,” нь яг ямар шалтгаанаас болсон бэ (ишлэл 33)?

6. Есүс түүнтэй хамт уйлснаараа Марьд юуг илэрхийлсэн байж болох вэ (ишлэл 35)?

- Таныг хайртай нэгнээ эцсийн замд нь үдэхэд, эсвэл таны амьдралд учирсан харуусалд та мэдээгүй ч Есүс тантай хамт уйлдаг. Энэ нь танд юуг илэрхийлдэг вэ?

7. Марта Есүсийг ямар зорлигтойгоор хадан булшийг нээхийг хүссэн гэж бодсон бэ (ишлэл 38-39)?

- Есүс түүний ахыг үхлээс дахин амилуулна гэдэгт Марта итгэж байсан уу?
- Есүс ишлэл 40 дэх үгээрээ юуг илэрхийлсэн бэ?

8. Есүс ишлэл 41-42 дахь залбирлаараа яг юуг гуйсан бэ?

- Тэнд байсан хүмүүс Лазарыг булшнаас гарч ирэхийг хараад хэрхэн хүлээн авсан гэж та боддог вэ (ишлэл 43-44)?

9. Лазарын булшинд болсон үйл явдлаас болж Марта болон Мари нарын итгэл хэрхэн өөрчлөгдсөн бэ?

- Тэнд байсан Иудейчуудад энэ гайхамшиг нь хэрхэн нөлөөлсөн бэ (ишлэл 45-46)?
- Яагаад зарим хүмүүс үүн шиг гайхамшиг гэрчилсэн ч итгэлгүй байдалдаа үлддэг вэ?

10. Та Лазарыг амьдрал уруу дахин ирэхдээ юуг мэдэрсэн гэж боддог вэ?

- Есүс энэ үйл хэргийн төлөө сүүлд ямар үнэ төлөхөө бүрэн мэдэж байсан мөртлөө яагаад Лазарыг үхлээс амилуулсан бэ (ишлэл 53)?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс зөвхөн төлөх ёстой өрөө төлөн үхсэн (учир нь нүгэл бол үхлийн хөлс) хүнийг үхлээс дахин амилуулсан. Үүний дараахан Есүс өөрийн үхлээрээ Лазарын нүглийн төлөөсийг төлсөн. Энэ бол Есүс таны, миний, бидний хайртай хүмүүсийн төлөө амь ба амилал болсны шалтгаан юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 15. УЛААН БУУДАЙН ҮХСЭН ҮР (Иохан 12:20:21)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Энэ нь Есүсийн дэлхий дэх амьдралын сүүлчийн шөнө байсан. Тэр дараа өдөр нь алуулна гэдгээ мэдсэн. Аврагч эдгээр үгсээр бидэнд үхлийн өмнө зүрх сэтгэлд нь ноцож байсан ширүүн тэмцлийг илэрхийлсэн.

1. Яагаад Грекчүүд өөрсдийн шаардлагаар шууд Есүс рүү очоогүй вэ (ишлэл 20:21)?

- Яагаад Филип өөрийн шаардлагаар шууд Есүс рүү очоогүй вэ (ишлэл 22)?

2. "Өөрийн амийг хайрлагч хүн" гэсэн нь бодит байдалд юуг илэрхийлж байна вэ?

- "Энэ ертөнцөд өөрийн амийг үзэн яддаг хүн" гэсэн нь бодит байдалд юуг илэрхийлж байна вэ?
  - Яагаад хүн хийж байгаа зүйлээ амьдралынхаа зорилго болгосноороо аз жаргалыг олж авдаггүй вэ?
- Ишлэл 26 шавь нарын туршлагад юуг илэрхийлсэн вэ ?
- Та ишлэл 26-г өөрийн амьдралд хэрхэн бодитоор хэрэгжүүлж чадах вэ?

3. Энэ үед Есүсийн зүрхэнд ямар тэмцэл ноцож байсан бэ (ишлэл 27-28)? (Есүс эдгээрээс алийг нь сонгосон бэ?)

- Есүс энэ дэлхийд ирэхээсээ өмнө ч хүн төрөлхтний нүглийн төлөө үхэхээр шийдсэн байсан. Гэсэн хэдий ч Тэрээр энэ нөхцөлд яагаад тийм их шаналсан бэ?
- Юу Есүсийг улаан буудайн үрийн замыг сонгоход хүргэсэн бэ?

4. Хэрэв та: өөр хэнд ч ач тусгүй аз жаргалтай амьдрал, эсвэл бусдад агуу ивээл авчрах зовлонгоор дүүрэн амьдралын аль нэгийг нь авах болвол алийг нь сонгох вэ? Өөрийн тайлбарыг өг.

5. Та : "Гэвч Би энэ зорилгын төлөө энэ цагт ирсэн" гэж хэлсэн Есүсийн үгийг өөрийнхөө зовлонтой холбоотой гэж хэлж чадах уу (ишлэл 27)?

6. Есүсийн өөрийн амьдралдаа тавьсан хамгийн гол зорилго нь юу байсан бэ (ишлэл 28-29)?

- Яагаад Бурхан Эцэгийн нэр нь Хүүгийнхээ үхлээр алдарших ёстой байв?

7. Ишлэл 31 ба 32 юуг илэрхийлдэг вэ?

8. Филип ба Андрей нарын шаардлагад Есүс ямар хариулт өгсөн бэ (ишлэл 23-33)?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс биднийг хайрласан хайрынхаа улмаас бидний төлөө амиа алдсан. Тэгвэл биднийг хайрлагчийн улмаас Түүний төлөө бид амиа өгч чадахгүй юу?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 16. ЭЗЭН БООЛ (ишлэл 13:1-17)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Есүс нэгэн өрөө түрээслээд шавь нараасаа Дээгүүр Өнгөрөх баярын хоолыг бэлдэхийг хүссэн. Тэнд ус, түмпэн, алчуур бэлэн байсан боловч хоолны өмнө хүн бүрийн хөлийг угаах хүн байгаагүй. Хүмүүс хагас хажуулдсан байдалтай хоололдог байсан бөгөөд хажуу хүнийх нь угаагаагүй хөл бусдынхаа идэх дурыг бууруулдаг байв.

1. Есүс дараа өдөр нь үхнэ гэдгээ мэдэж байв. Хэрэв та маргааш үхнэ гэдгээ мэдвэл өнөөдөр юу хийх вэ?

- Ишлэл 3 бусад үйл явдлын талаар юу хэлж байна вэ?

2. Яагаад шавь нараас хэн нь ч боолын ажлыг хийхийг хүсээгүй вэ? (Яагаад хамгийн залуу нь ч адил бусдынхаа хөлийг нь угааснаар тэдэнд үйлчлэхийг хүсээгүй вэ?)

- Яагаад “үнсэх заншил” хүмүүс бидэнд тийм чухал байдаг гэж боддог вэ?

3. Шавь нар хөлөө угаалгүйгээр Дээгүүр Өнгөрөх баярын хоолыг идэхдээ юу бодсон гэж та бодож байна вэ?

- Яагаад Есүс шавь нарыгаа хоолоо идэж эхэлсний дараа хөлийг нь угаасан гэж та таамагладаг вэ (ишлэл 4)?

4. Энэ үйлдлээрээ дамжуулан Есүс Өөрийнхөө талаар юу илчлэхийг хүссэн бэ?

5. Хэрэв таны өмнө нь татгалзсан зүйлийг Есүс хийвэл та хэрхэн хүлээн авах вэ?

6. Яагаад Петр Есүсээр угаалгахаас татгалзсан бэ (ишлэл 6-8)?

- Ишлэл 8-дахь үгс Петрийн тухай юуг байна вэ?
- Таны бодлоор Есүсээр хөлөө угаалгаагүй хүн яагаад Есүсийнх биш гэж хэлэгдэх вэ (ишлэл 8)?

7. Петр яагаад гэнэтхэн Есүсээр гар, толгой, түүнчлэн хөлөө угаалгахыг хүссэн гэж та боддог вэ (ишлэл 9)?

- Есүс ишлэл 10-т Петрт өгсөн хариултаараа юуг илэрхийлдэг вэ? (Тэр “бие угаах” болон “хөлөө угаах”-ыг юутай холбодог вэ?)
- Есүс нүглийг тань угаасан гэж та хэлж чадах уу? Хэрэв та ийнхүү хэлж чадвал энэ нь хэзээ, хаана тохиолдсон бэ?

8. Яагаад Есүс Иудасын хөлийг хүртэл угаахыг хүссэн бэ (ишлэл 2,11)?

- Есүс Иудасын өмнө нь өвдөг сөгдөх үед тэр юу мэдэрсэн гэж та боддог вэ?
- Иудасыг Есүсийн хайранд итгэсэн гэж та бодож байна уу?
- Иудас ямар том алдаа хийсэн бэ?

9. Есүсийн энд бидэнд үзүүлсэн жишээг өнөөдрийн Христэд итгэгчид хэрхэн дагаж чадах вэ (ишлэл 12-17)?

- Хэрвээ Христчин хүн Есүсээр хөлөө угаалгаагүй бол яагаад бусдын хөлийг угаах нь боломжгүй вэ?

10. Яагаад энэ онцгой тохиолдолд Есүс “Өөрийн дүүрэн хайрыг” харуулсан бэ (ишлэл 1)?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс загалмай дээрх үхлээрээ, “Хэн та нарын дунд агуу болохыг хүснэ, тэр хүн та нарын зарц болог. Мөн хэн та нарыг дунд тэргүүн байхыг хүснэ, тэр хүн бүгдийн боол болог.

Учир нь хүний Хүү хүртэл үйлчлүүлэхийн тулд бус үйлчлэхийн тулд ирсэн.” (Марк 10:43-45) гэж хэлснээрээ зарц, боолын ажлыг хийсэн.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 17. ЗАМ, ҮНЭН, АМЬ (Иохан 14:1-11)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Хэрэв бид маргааш тамлуулан алагдана гэдгээ мэдвэл бусад хүмүүсийн шаналсан зүрх сэтгэлийн талаар бодохдоо цовоо сэргэлэн байх хүн бидний дундаас хэр олон бэ?

1. Таны бодлоор, шаналсан зүрх сэтгэл ба гунихарсан сүнс нь итгэлгүй байдлыг харуулдаг уу?
  - Өнөөдөр таныг юу зовоож байна вэ? (Та өөрийн зүрх сэтгэлдээ хариулж болно)
2. Ишлэл 1 ямар утгатай вэ?
  - Хүн санаа зовох үедээ Бурхан буюу Есүс итгэх ёстой талаар ямар баримтууд байдаг вэ?
3. Есүс ишлэл 11-д итгэлийн талаар юу хэлдэг вэ? Энэ сэдэвт дурдагддаг бүх зүйлсийг сайтар хар.
4. Ишлэл 2 ба 3-аас бид тэнгэрийн хаанчлалын тухай юу сурдаг вэ?
  - Эхний ишлэл нь хоёр ба гурав дахь ишлэлтэй ямар холбоотой вэ?
    - Ямар нөхцөл байдлаар тэнгэрийн хаанчлал таны хувьд чухал болсон бэ?
5. Есүс “Би бол зам” гэж баталсанаараа юуг илэрхийлдэг вэ (ишлэл 6)?
  - Хэн нэгэн нь “энд зам байна”, эсвэл “ Би бол зам” гэж хэлэхийн хооронд ямар ялгаа байдаг вэ?
  - Яагаад Есүсээр дамжилгүйгээр хэн ч тэнгэрийн хаанчлал уруу орж чадахгүй вэ?
6. Есүс бол “үнэн, амь” гэсэн нь ямар утгатай вэ (ишлэл 6)?
7. Ишлэл 7-11 бидэнд Бурхан ба Есүсийн хоорондын харилцааны талаар юуг заадаг вэ?
  - Хэрэв Есүс бол Бурхан гэдэгт итгэхгүй бол яагаад хэн ч Христэд итгэгч болж чадахгүй вэ?
8. Есүсийн эдгээр урамшууллын үгсийг хэнд өгүүлсэн бэ? Тэд ямар шавь нар нь байсан бэ (Иохан 13:37-38, 14:5, 8, 9)?
  - Тэд гурван жилийн турш хамтдаа байсан боловч шавь нар нь яагаад Есүс болон өөрсдийнхөө талаар тийм өчүүхэн сурсан бэ?
9. Есүс Өөрөө сүүлчийн шөнөө гашуудалд автсан боловч шавь нараа санаа зовохыг хориглосон. (Уншигч Матай 26:37-38 уншиж болно). Та энэ нөхцөлд Есүсийн үг ба үйлсийн хоорондын ялгааг хэрхэн тайлбарлах вэ?
  - Гетсемен цэцэрлэгт Есүсийн санааг юу зовоож байв?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүсийн санааг Бурханы уур хилэн, нүглийн хөлс үхлээс өөр зүйл огт зовоогоогүй. Тэр бидний оронд эдгээр зүйлсэд санаа зовсон учраас бидэнд “Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд мөн Надад итгэ.” гэж хэлэх эрхтэй болсон. Тэдгээр үгс нь өнөөдрийн танд зориулсан Есүсийн онцгой мэндчилгээ юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 18. ЖИНХЭНЭ УСАН ҮЗМИЙН МОД (Иохан 15:1-11)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Израйль Өмнө Эзэний усан үзмийн мод байсан. Хэдий тийм ч тэд үр жимсгүй болсон учраас Түүний урмыг хугалах болсон (Исаиа 5:1-7). Есүс энэ сэдэвт Өөрийгөө Бурханыг сэтгэл хангалуун болгож чадах ганц жинхэнэ усан үзмийн мод гэж баталдаг. Усан үзмийн модны хатуу шилбийг өвөл бүр тайрдаг байв. Нэг усан үзмийн мод хоёроос гурван хатуу шилбэтэй болдог.

1. Усан үзмийн мод ба Есүсийн хооронд байж болох адил төсөөтэй талуудыг бодохыг хичээ.
  - Христэд итгэгчид ба усан үзмийн модны мөчрийн хооронд ямар адил талууд байдаг вэ?
2. Таны бодлоор, яг ямар Христэд итгэгч хүн их жимс ургуулдаг вэ?
  - Эхний дөрвөн ишлэлийн санаан дор үр жимс төрөх үйл явцыг хэлэлц. Усан үзмийн модны мөчрүүд (бид), усан үзмийн модны шилбэ (Есүс), мөн энэ үйл явцын цэцэрлэгч Бурхан ямар хариуцлагатай вэ?
3. Хэдийгээр таслагдах ёстой боловч усан үзмийн модны хамгийн үзэгслэнтэй, ил харагдах тал нь навч юм. Хэдийгээр Бурхан тасалсан боловч өөрийн амьдралд “ургуулахыг” хүссэн ямар зүйл танд байсан бэ? (Та зүрх сэтгэлдээ хариулж болно.)
4. Усан үзмийн модны мөчир ямар шалтгаанаас блж унадаг вэ? Жишээлбэл, мөчир лүү урсан орох шүүсийг юу саатуулж болох вэ?
  - Христэд итгэгчийг Есүсээс салгах ямар шалтгаанууд байж болох вэ?
  - Таныг таслагдан унгах ямар аюулууд байна вэ? (Та өөрийн зүрх сэтгэлдээ хариулж болно.)
5. Итгэлээ хаясан хүмүүст юу тохиолддог вэ? Ишлэл 6 энэ талаар ү хэлж байна вэ?
6. Энэ хэсгээс жимс төрүүлэхэд шаарлагатай байж болохуйц нөхцлүүдийг олохыг хичээ.
  - Энэ хэсэгт “үлдэх” (байх) гэсэн үйл үг хэр олон удаа гардаг вэ?
  - Шавь хүн үр жимс төрүүлэхийн тулд хаана үлдэх ёстой вэ?
  - Есүсийн үгс бидний дотор хэрхэн үлдэж болох вэ (ишлэл 7)? (Бидний дотор үлдсэн Есүсийн үгсийн эсрэг ямар үг байж болох вэ?)
7. Нэг тал нь бусдын шаардлагыг анхаардаггүй байвал энэ нь харилцааны талаар юуг харуулдаг вэ (ишлэл 10)?
  - Хэрэв Христэд итгэгч хүн Есүсийн тушаалуудыг анхаардаггүй бол энэ нь тэрхүү Христэд итгэгчийн талаар юуг харуулдаг вэ?
  - Хэрэв та Есүсийн тушаалуудад дуулгавартай байгаагүй гэдгээ ойлгосон бол юу хийх ёстой вэ?
8. Бид нэг нэгнээ хайрлах хайр дотор хэрхэн үлдэх вэ (ишлэл 9)?
  - Бид Есүсийн хайр дотор хэрхэн үлдэх (байх) вэ (ишлэл 9)?
9. Библи судалгаанаас гэрийнхэндээ хүргэх үг нь ишлэл 9. Эцэг нь Түүнийг хайрласны адилаар Есүс таныг хайрласан нь танд юуг илэрхийлдэг вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Бидэнд байх ёстой тийм их үр жимсийг бидний хэн нь ч тариаагүй. Есүс биднийг орлон тэрхүү үр жимс ургуулдаггүй мөчир болсон. Гэсэн ч тэр хэний ч ургуулж чадхааргүй үр жимсийг тарьсан бөгөөд “галд хаягдан шатах ёстой” болсон (ишлэл 6).

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## **19. УЙ ГАШУУ ЧИНЬ БАЯР БАЯСГАЛАНГААР СОЛИГДОНО (Ишлэл 16:20-24, 32-33)**

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Есүс энэ хэсэгт дараа өдөр өөийх нь үхлээс болж шавь нарт нь тусах үр нөлөөний талаар ярьдаг.

1. Яагаад ертөнц Есүсийн үхлийн тухайд баярлах боломжтой болсон бэ? (ишлэл 20)
2. Есүс эмэгтэйн төрөлтийн тухай дүрслэлээр бидэнд юуг хэлэхийг хүссэн бэ? (ишлэл 21)
  - Шинэ зүйл төрөх үед яагаад үргэлж зовлон болон өвчин байдаг вэ?
  - Таны өөрийн эсвэл таны хайрлдаг нэгний амьдрал руу таны мэдэрсэн зовлонгоор ямар шинэ зүйл бий болсон бэ?

- Есүс ишлэл 21-д магадгүй Өөрийн үхлийн талаар дурдсан байх. Тэр төрөлтийн баяр хөөрөөр юуг хэлэхийг хүсдэг вэ?
3. Уй гашуу ба баяр хөөр нь хэрхэн хамтдаа байж болох вэ (ишлэл 22)?
    - Ямар төрлийн зүйлс биднээс баяр хөөрийг минь булаадаг вэ (ишлэл 22)?
    - Биднээс хэн ч үл булааж чадах ямар баяр хөөр бидэнд байдаг вэ?
  4. Есүсийн хэлсний дагуу залбирал Бурханы сонорт хүрэх ямар нөхцөл байдаг вэ (ишлэл 23, 24)?
    - Зүгээр Бурханд залбирах ба Түүнд хандан Есүсийн нэрээр залбирах хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ?
  5. Есүс бидний Түүнээс гуйсан алив зүйлийг тэнгэрлэг Эцэг нь өгнө гэсэн амлалтаараа юуг илэрхийлдэг вэ (ишлэл 23, 34)?
    - Та ишлэл 23 ба 24-ийн амлалтууд танд ч бас хүчинтэй гэдэгт итгэдэг үү? Өөрийн тайлбарыг өг.
    - Таны Христчин амьдралын турш дахь залбиралуудад хамгийн гайхамшигтай хариулт нь юу байсан бэ?
  6. Есүс ишлэл 33-д Христэд итгэгчид энэ дэлхийд байх туршдаа зовлонтой байна гэж хэлдэг. Есүс “зовлонтой байна” гэж хэлснээрээ ямар зүйлийн талаар дурддаг вэ?
    - Яагаад ихэнх Христэд итгэгчид ямар ч зовлонгүй амьдралыг хайдаг вэ?
  7. Бид зовлон дунд байхдаа ч Есүсийн дотор амар тайван байдаг гэсэн нь ямар утгатай вэ?
    - Таны бодлоор, хэрэв Христчин хүн эхлээд зовлон Бурханы мутраас ирдэг гэдэгт итгэдэггүй бол тэр зовлон дундаа амар тайван байж чадах уу? Өөрийн тайлбарыг өг.
  8. Есүс дэлхийг ялсан гэдэг нь ямар утгатай вэ? (ишлэл 33)?
    - Есүс ишлэл 33-ыг өнөөдөр хувьчлан танд хэлэхийг хүсч байна. Түүний үг таны өнөөдрийн нөхцөл байдалд ямар утга илэрхийлж байна вэ?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 20. ЕСҮС ӨӨРИЙНХӨӨ ТӨЛӨӨ ЗАЛБИРСАН НЬ (Иохан 17:13-21)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Энэ бол Есүсийн шавь нартайгаа хамт байхдаа тэдний төлөө залбирсан хамгийн сүүлчийн залбирал юм. Тэр тун удалгүй шавь нар нь Түүнийг орхино гэдгийг мэдэж байв. Энэ хэсэгт байдаг үг, өөрөөр хэлбэл “ ертөнц” нь Иоханы Сайн Мэдээнд хамгийн их байдаг. Энэ нь тус Сайн Мэдээнд нийтдээ 50 удаа гардаг. Удирдагч дараах жишээнүүдийг уншиж болно: Иохан 1:9-11; 9:5; 15:18-19, 16:33.

1. Та удахгүй нас барна гэдгээ мэдвэл хайртай хүмүүсийнхаа төлөө юу гэж залбирах вэ?
2. ӨМГӨӨЛӨЛ (Ишлэл 11, 12, 15)
  - Та Бурхан таныг болон таны хайрладаг нэгэнийг юунаас хамгаалаасай гэж хүсдэг вэ?
  - Есүс өөрийнхнийгөө юунаас хамгаална гэж амладаг вэ? (Яагаад Есүс шавь нарыгаа зовлонгоос хамгаалаач гэж Эцэгээсээ гуйгаагүй вэ?)
  - Есүс биднийг хамгаална гэсэн амлалтаараа юуг илэрхийлдэг вэ?
3. ЕРТӨНЦ (ишлэл 13-18)
  - Есүс энэхүү сүүлчийн залбирлаараа ертөнцийн талаар юу хэлдэг вэ?
  - Есүсийн шавь нар ба ертөнц хоёрын хооронд ямар том ялгаа байдаг вэ?
  - Ертөнц яагаад Христэд итгэгчдийг үзэн яддаг вэ (ишлэл 14)?
  - Христчин хүнийг ертөнцтэй харьцах харилцааны хувьд ямар хоёр аюул байдаг вэ? (Яагаад өөрийнхнийгөө ертөнцөөс тусгаарлахыг хүсээгүй вэ---жишээлбэл тэднийг сүм хийдэд суулгах гэх мэт, ишлэл 18?)
  - Өөрийн ертөнцтэй харилцаж буй харилцааныхаа талаар бод. Яг Есүсийн хүссэнээр байна уу?

- Энэ талаас нь та өөрийн Христчин нөхөрлөлийг хэрхэн үнэлэх вэ? Та Есүсийн сүүлчийн залбиралдаа залбирсан шиг дэлхийтэй харилцаж байнауу?

#### 4. БАЯР ХӨӨР (ишлэл 13)

- Христчин хүний бүрэн дүүрэн баяр баясгалангийн үнэлэмж хаанаас ирдэг вэ?
- Есүс өөрийн шавь нараа тэднийг үзэн яддаг, хавчдаг ертөнцөд амьдрахдаа ч баяр баясгалантай байж чадна гэж яагаад бодов?
- “Баяр баясгалан” гэсэн үгийг тодорхойл—Есүс үүгээр юуг илэрхийлдэг вэ?
- Хэрэв та өөрийн амьдралд ямар ч баяр хөөр алга гэдгийг мэдвэл ямар шалтгаанаас ийм болсон гэж бодож байна вэ?

#### 5. БУРХАНЫ ҮГ (ишлэл 14, 17, 19)

- Танд Бурханы үг, Библи нь үнэн гэдэгт итгэх нь хэцүү юу эсвэл амархан уу (ишлэл 17)? Өөрийн тайлбарыг өг.
- Хэрэв Христчин хүн Библийн нэг хэсэгийг өнөө үед хүчингүй гэсэн шалтгаанаар үгүйсгэвэл юу болох вэ?
- Есүс үнэн биднийг ариусгана гэж хэлэхдээ юуг илэрхийлдэг вэ (ишлэл 17)?

#### 6. ДҮГНЭЛТ

- Есүсийн сүүлчийн залбирал нь бидэнд “Сүнсний тулалдааны” талаар юу сургадаг вэ? (Хэрвээ та энэхүү томъёололтой танил биш бол энэ асуултыг алагсаж болно)
- Энэ залбиралын юу нь таны зүрх сэтгэлд хамгийн гүнзгий хүрдэг вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун!” (Иохан 1:29). “Бурхан өртөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн” (Иохан 3:16).

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 21. ЕСҮС БАРИВЧЛАГДСАН НЬ (Иохан 18:1-14)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Иерусалимын газрын зураг дээрээс Кидроны хөндий ба Гетсеменыг хар. Иудасын тухай Иохан 12:6 унш. Энэ үйл явдал блосноос хоёр өдрийн дараа Иудас амиа хорлосон. Энд буй баривчлагдчын ихэнх нь Иудейн сүмийн харгалзагчид байсан гэдгийг анхаар (ишлэл 3).

1. Гурван жилийн өмнөөс Есүсийн хамт байсан Иудаст хэр их зүйлс мэдсэнийг төсөөл. Түүнд ямар урам хайрлах мөн урам хуграх зүйлүүд тохиолдож байсан бол?
  - Та Есүсийг бусад дагалдагчдыг хайрласан шигээ Иудасыг хайрласан гэж боддог уу?
  - Иудас Есүсийн хайранд итгэсэн үү? Итгэсэн бол яагаад? Итгээгүй бол яагаад?
2. Есүс яагаад Иудасыг мөнгөний уут хадгалагч болгосон гэж та боддог вэ (Иохан 12:6)?
  - Яагаад мөнгөний шуналд хүнийг захирах тийм их эрх мэдэл байдаг вэ?
  - Та ямар нөхцөлд Есүс болон өөрийн Христчин итгэлээсээ урваж болзошгүй вэ?
3. Яагаад Есүсийг өдрөөр биш харин, шөнөөр баривчилсан вэ?
  - Олон олив моддын дундах Гетсемен цэцэрлэгийн дүр төрх ба харанхуй дахь хөлний чимээ, гэрэлтсэн бамбайнууд, хашгиралдааныг төсөөл. Таны хувьд энэ нөхцөлд хэн айсан мэт санагддаг вэ? Хэн зоригтой байсан мэт сэтгэгдэг төрүүлдэг вэ (ишлэл 3-6)?
4. Есүс яагаад өөрийг нь баривчлахыг хүссэн хүмүүст бүрэн харагдахын тулд харанхуйд урагш гарсан бэ (ишлэл 4)?
  - Есүс “Би байна” хэмээн Бурханы нэрийг дурдсан. Яагаад Түүнийг баривчлах гэсэн хүмүүс үүнийг сонсоод гэдрэг унав (ишлэл 6)?
5. Есүс баригдах үедээ юунд хамгийн ихээр санаа зовов?

- Ишлэл 8-9-ийг “алдартай солилцоо” гэж тодорхойлдог: Есүс нүгэлтнүүдийн байрлалыг авсан бөгөөд ийнхүү үйлдснээрээ тэднийг Бурханы уур хилэнгээс зугтаах бололцоо олгов. Есүсийн ишлэл 8-ийг сатаны өмнө хэлээд тань руу эсвэл таны хайртай хүн рүү зааж байна хэмээн төсөөлөөд үз. Ийм маягаар унших юм бол энэ нь танд юуг илэрхийлж байна вэ?

6. Петрийн сэлмээр тэмцсэн зорилго нь юунд байв (ишлэл 10)?

- Бусад Сайн Мэдээнүүд нь Есүс хамгийн сүүлчийн гайхамшигаараа Малчхын чихийг эдгээсэн гэдгийг бидэнд хэлдэг. Яагаад тэр ийнхүү үйлдэв?
- Та Малчхс тэр шөнийн болсон үйл явдлын талаар гэрийнхэндээ юу ярьсан гэж боддог вэ?

7. Үүнээс өмнөхөн Есүс Эцэгээсээ гурван удаа энэ зовлонгийн аягыг Түүнээс зайлуулаач гэж гүйсан. Яагаад энд Тэр үүнийг сайн дураараа, уриалагханаар хүлээн авсан бэ?

- Есүст хэн энэ зовлонг тохсон бэ (ишлэл 11)?
- Та өөрийнхөө зовлонгийн талаар Есүсийн ишлэл 11-д үйлдсэн тэрхүү замаар ярьж чадах уу?
- Сатаны гараас, муу хүмүүс эсвэл тэнгэрлэг Эцэгийнхээ гараас хүлээн авсан зовлонгууд нь ямар ялгаатай байдаг вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Ишлэл 11 дэх аяга нь энэ ертөнцийн бүх бузар, нүглүүдийг агуулдаг: Сонингууд өдөр бүр хэрцгий балмад явдлын тухай өгүүлдэг (Илчлэл 17:4). Энэ аягыг ууснаар Есүс өөр лүүгээ энэ бүх бузрыг цутгаж, тэр нь түүний нэг хэсэг болсон юм. Ингэснээрээ тэр дэлхий дээрх бүх нүгэлт хүмүүсийн мөн таны ч орлогч юм.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 22. ТӨГСЛӨӨ! (Иохан 19:25-30)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Цовдлол нь хүнийг тамлахад зориулагдсан хамгийн хэрцгий арга байсан байж магадгүй. Цовдлогдсон хүнийг ярихад хамгийн хэцүү зүйл нь юу байсан бэ гэвэл тэрхүү амьсгалах болгондоо хадагдсан хөл дээрээ хүндийнхээ жингээр дардаг байсан. Есүс загалмай дээр өлгөгдөхдөө үнэндээ тамд байсан, учир нь Бурхан Түүнийг тэр үед орхисон юм. Есүсийн хайрласан шавь нь үнэндээ Иохан өөрөө байсан (ишлэл 26).

1. Ишлэл 25-27

- Та яагаад загалмайн дор цугласан Есүсийн хамгийн дотны найзууд нь эмэгтэйчүүд байсан гэж боддог вэ? (Зовлонгийн тухай гэрчлэлийг хүчийг нь бууруулалгүйгээр гэрчилж буй эрэгтэй ба эмэгтэйчүүдийн хооронд ялгаа байдаг гэж та боддог уу?)
- Яагаад Есүсийн эх Мариа загалмай дахь өөрийн Хүүгээсээ холдож чадаагүй вэ?
- Энэ нөхцөлд Мариад юу хамгийн хэцүү байсан гэж та боддог вэ??
- Энэ нөхцөлд тохиолдоно гэж Марийн хүлээж байсан зүйл аль нь вэ; ямар нэгэн гайхамшиг болох, эсвэл Түүний Хүү тун удахгүй нас барах.
  - Есүсийг гутаасан энэхүү үйл явдалын гэчлэгч болсон Марь түүнийг Бурханы хүү гэдэгт итгэсэн хэвээрээ байсан болов уу? Өөрийн хариултыг өг.
- Хүүгийнх нь Мариад хандаж хэлсэн сүүлчийн үг түүнд хэр их чухал байсан бэ? Есүс эхдээ юу ч хэлэлгүйгээр нас барсан нөхцөл байдлаар төсөөлөөд үз.
- Яагаад Есүс ээжийгээ өөр хүний бус Иоханы халамжинд үлдээхийг хүссэн бэ? (Хэрэв Мариа Есүсийг нас барсны дараа үлдсэн дөрвөн хүүхдүүд дээрээ очсон бол түүний нөхцөл байдал ямар ялгаатай байх байв? Хүүхдүүд нь Түүнд хараахан итгээгүй байсан гэдгийг анхаар.)
- Та Есүс энэ түүхээрээ таны эцэг эхтэйгээ харьцах харьцааны талаар юу заахыг хүссэн гэж бодож байна вэ?

2. Ишлэл 28-29

- Яагаад цовдлогдсон хүмүүс маш их цангадаг байсан талаарх янз бүрийн шалтгаануудыг бод.
- Загалмай дээрх Есүс уснаас гадна өөр юугаар цангаж байсан бэ?
- Есүс нэг удаа цугласан олны өмнө, “Хэрэв цангасан хүн байвал Над уруу ирж уугтун” гэж хэлсэн (Иохан 7:37). Яагаад Амийн Усны эзэмшигч энд цангасаар нас барах ёстой байв?

### 3. Ишлэл 30

- Удирдагч баптисм хүртэхийнхээ өмнөхөн хэлсэн Матай 3:15 дахь Есүсийн үгийг унших ёстой. Тэдгээрийг ишлэл 30 тай харьцуул.
- Та Есүс таны өмнөөс бүх зөвт байдлыг гүйцэлдүүлсэн гэдэгт итгэдэг үү (Бурханы бүх тушаалууд)?
- “Есүс нас барсан”, “Есүс сүнсээ алдсан” гэсэн эдгээр хоёр илэрхийлэл нь хоорондоо ямар ялгаатай вэ?
- Есүсийн эцсийн цаг мөчийг та үхэхийг нь харсан хэн нэгнийхээ эцсийн цаг мөчтэй харьцуул. (Есүсийн зан чанарт хосгүй ямар чанар байсан бэ?)

**БАЯРТ МЭДЭЭ:** Лазарын болон баян хүний тухай бибэл дэх түүх нь бидэнд там бол цангадаг газар гэдэгийг хэлдэг. Баян хүн Лазараас хэлэн дээрээ тусгах нэгхэн түсал усыг гүйсан (Лук 16:24). Есүс таныг үүрд цангаахгүйн тулд өөрөө тэрхүү тамын цангааг амсаж зовох болсон.

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 23. ХООСОН БУЛШНИЙ ГАДНА (Иохан 20:11-18)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Удирдагч Луук 8:1-3-ыг унших ёстой. Есүсийн гашуун зовлонгийн төгсгөлийн үед загалмайн дэргэд зогсож байсан, мөн Есүсийн булшний тухай гэрчлэлд ч хажууд нь байсан Мариа нь шавь нартай адилгүй байв (Матай 27:61). “Рабуны” (ишлэл 16) гэсэн үг нь Сайн Мэдээнүүдэд зөвхөн хоёр удаа л гардаг. Энэ нь “рабби” (багш)-аас илүү хүчтэй утгатай.

1. Та Марийн амьдралыг долоон бузар сүнснүүдэд эзэмдүүлсэн үедээ ямар байсан гэж боддог вэ? (Түүний өдөр тутамын амьдрал ямар байв? Түүний хувийн харилцаа ямар байв? Тэр бузар сүнснүүдийн нөлөөгөөр “унадаг” байсан уу?)
  - Магдалын Марийг Есүстэй хамт эргэн тойрныхоо газруудаар аялсан жилүүдийнхээ туршид ямархуу байсан гэж та боддог вэ?
  - Марь ямар хайраар Есүсийг хайрласан бэ? Тэр эмэгтэйн Түүний тухайд хэрэглэсэн томъёолуудыг ажигла (ишлэл 13, 16, 18).
2. Мариа Есүсийн гашуун зовлонгийн төгсгөл хүртэл загалмайн дэргэд зогссон бөгөөд Есүсийн булшийг ч бас харсан. Энэ нь Түүний талаар бидэнд юуг харуулдаг вэ?
  - Мариа Есүсийн нас барсаны дараах нэг өдөр хоёр шөнийг хэрхэн өнгөрилсэн гэж боддог вэ?
3. Мариа яагаад тэрхүү булш хоосон байсан боловч тэнд үлдэхийг хүссэн бэ (ишлэл 11)?
  - Мариа нас барсан Есүсийн биеийг дахин харахгүй, бүр түүнд хуруугаа ч хүргэж ч чадахгүй гэсэн бодол нь яагаад түүнийг тэгэж их сандрагсан бэ?
4. Яагаад Мариа булшины дэргэд хоёр тэнгэр элчийг харсан боловч гайхан мэдгээгүй мэт санагддаг вэ? Янз бүрийн тайлбаруудыг бод (ишлэл 12-13).
5. Мариа Есүсийг харж, түүнтэй ярисан боловч яагаад түүнийг таниагүй вэ? Янз бүрийн тайлбарыг бод (ишлэл 14).
  - Есүс таныг гашуудах үед хажууд чинь байхад та Түүнийг таниагүй үе танд тохиолдож байсан уу? Хэрэв ийм зүйл танд тохиолдсон бол тэр нь ямар нөхцөлд байсан бэ?
6. Хариултыг нь аль хэдийн мэдэж байсан боловч Есүс болон тэнгэр элч нар Мариас яагаад уйлсаныг нь асуусан бэ?
  - Аль хэдийн шалтгааныг нь мэддэг боловч уйлж байгаагаа Өөрт нь хэлэхийг Есүс яагаад танаас хүсдэг вэ?
    - Мариагын нулимс дэмийн хоосон байсан уу? Өөрийн хариултыг өг.
  - Бидний нулимс дэмий эсвэл дэмий хоосон бус урсдаг эсэхийг бид хэрхэн мэдэж чадах вэ?
7. Мариа цэст нь хэрхэн Есүсийг таньсан бэ (ишлэл 15-16)?

- Яагаад Есүс Марийг мэдрэмжийнхээ дагуу сэтгэл нь хөдөлсөн байхыг хүсээгүй вэ (ишлэл 17)?
- Бид энэ нөхцөлд Есүсийн хувь хүний зан чанараас нь юуг сурч болох вэ?

8. Тэр үед эмэгтэй хүмүүсийг шүүх танхимд гэрчээр хүлээн зөвшөөрдөггүй байсан. Яагаад Есүс эхлээд эмэгтэйд харагдаад дахин амилсаны анхны гэрчлэлээ түүнд илэрхийлсэн бэ?

- Есүс нийгмийн шудрага бус удирдагчдад, тухайлбал, чауминизм эсвэл Саббат өдрийн нарийн заавруудын баримтлагчдад хязгаарлагдаагүй. Яагаад Тэрээр Иудасыг нас барсны дараа Марийг арван хоёр дахь шавь болгоогүй вэ? Та юу гэж бодож байна вэ?

9. Есүсийн дахин амилалт Марийн үлдсэн амьдралыг хэрхэн өөрчилсөн гэж та боддог вэ?

- Есүсийн дахин амилалт таны үлдсэн амьдралд ямар найдвар авчирдаг бэ?

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 24. ХАРДАГГҮЙ, ИТГЭДЭГГҮЙ! (Иохан 20:19-29)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Томасын Үгс Шинэ Гэрээнд зөвхөн гурван удаа л дурдагддаг. Удирдагч Иохан 11:7-8, 16 ба 14:5-6 уншиж болно.

1. Томасын зан чанарт ямар сайн шинжүүд байсан бэ? Ямар муу зан занарууд байсан бэ?

- Та Есүс яагаад энэ хүнийг шавь нарынхаа нэгээр сонгосон гэж боддог вэ?
- Томас яагаад Есүсийн дахин амилсан бүтэн сайны өглөө бусад шавь нарын хамт байгаагүйг янз бүрийн шалтгаанаар эрэгцүүлэн бод.

2. Зарим шавь нар нь хоосон булш, хоосон даавууг харсан бас Магдалын Марийн гэрчлэлийг сонссон. Тэр үед эдгээр хүмүүс Есүсийн дахин амилсанд итгэсэн үү (ишлэл 19)?

3. Есүсийн дахин амилалтыг гурван зүйлээр гэрчилсэн байдаг: Хуучин Гэрээний зөгнөлүүд, Есүсийн Өөрийн тухай урьдчилан хэлсэн үгс, Түүний хамгийн дотны 10 найзууд санал нэгтгэйгээрв Гэсэн ч Томас яагаад итгэхгүй гэж шийдсэн бэ (ишлэл 25)?

- Таны хувьд: Томас бүх гэрчийн мэдүүлгийн улмаас Есүсийн дахин амилалтанд итгэсэн эсвэл тэр ийм үед ч бас итгээгүй хоёрын алинаар нь ойлгож болохуйц байна вэ?

4. Таны хувьд харалгүйгээр итгэхэд юу нь хамгийн хэцүү вэ?

5. Баяр хөөртэй шавь нарын дунд зөвхөн Томас л ямар ч баярлах шалтгаангүй долоо хоногийн турш дагалдан явсан. Та түүнийг эдгээр найман өдрийн турш хэрхэн мэдэрсэн гэж боддог вэ?

- Та яагаад Томас өөрийн замыг хөөлгүй бусад дагалдагчидтай хамт байсан гэж боддог вэ?
- Хэрэв тэр энэ үед найз нараасаа явсан бол юу тохиолдох байв?
- Христчин итгэлийн үнэний талаар эргэлзээтэй байхдаа бид Христчин нөхдөө орхин явбал бидэнд юу тохиолдох вэ?

6. Долоон хоногын дараа Томас өөрийнхөө үгийг Есүсийн амнаас сонсоод хархан хүлээж бвсан бэ?

- Томас үнэхээр Есүсийн соривонд хуруугаа хүргэсэн гэж та боддог уу? Өөрийн хариултыг өг.
- Энэхүү үйл явдалын дараа Томас Есүсийн загалмайн тухай юуг ойлгосон бэ?

7. Томас Шинэ Гэрээнд Есүсийг "Бурханы Хүү" гэж биш, "Бурхан гэж дуудсан анхны хүн байсан (ишлэл 28). Есүс бол Өөрөө Бурхан гэдэгт итгэх нь яагаад тийм хэцүү байдаг вэ?

- Та Томасын адилаар Есүсийн тухай тунхаглаж чадах уу?
8. Ишлэл 29 өнөөдөр танд хувьчлан юуг өгүүлж байна вэ?
- Хараагүй, мэдрээгүй байсан ч Бурханы өршөөл ба тусламжинд итгэх нь яагаад хэрэгтэй вэ?
9. Энэ хэсгээс үзвэл, Есүс Түүнд итгэхийг хүссэн боловч итгэж чадахгүй байгаа хүнтэй хэрхэн ханддаг вэ?
- Эргэлзээний эсрэг тэмцэж буй итгэл ба огт эргэлзээгүй итгэлийн хооронд ямар ялгаа байдаг вэ?

**БАЯРТ МЭДЭЭ:** Есүс загалмай дээр өлгөгдсөн байхдаа харалгүйгээр итгэсэн. Тэр Бурханы уур хилэнг амссан ч (Матай 27:46) Өөрийн Бурханыг Бурхан хэмээн дуудсаар л байсан. Энэ бол Тэрээр Томасын бүх эргэлзээний шийтгэлийг эдлэж зовсоны шалтгаан бөгөөд энэ нь одоо ч эргэлзсэн нэгэнд туслах чадвартай юм

© 2006 Баярт мэдээний Библийн судалгаа - [www.gladtidings-bs.com](http://www.gladtidings-bs.com)

## 25. ЧИ НАМАЙГ ХАЙРЛАДАГ УУ? (Иохан 21:15-19)

**СУУРЬ ОЙЛГОЛТ:** Петр энд Түүнд хайртайгаа хүлээж байгаа шигээ гурван удаа Есүсийг голсон. Түүнчлэн Матай 26:33 хар.

1. Та найзыгаа мэхэлсэн гэж төсөөл. Та түүнтэй дараа дахин уулзахад тэр гэнэт таниас: “Чи надад бусдаас илүү хайртай юу” гэж асуув. Та энэ асуултыг тэр юунаас болж тавьсан гэж бодох вэ?
  - Есүс яагаад Пэтрээс түүнийг бусад дагалдагчид аас илүү ихээр хайлдаг уу гэж асуусан бэ?
2. Грек эх дээр Петрийн хариултанд Есүсийн асуултандаа хэрэглэсэн үйл үгнээс өөр үгийг хэрэглэсэн байдаг. ( Есүс: Чи Намайг үнэхээр хайрладаг уу? Петр: Тиймээ, Би Таны нөхөр.) Яагаад Петр үйл үгийг нь өөрчлөн хариулсан бэ (ишлэл 15-16)?
  - Есүс гурав дахь асуултандаа Петрийн бүх хариултандаа хэрэглэсэн үгтэй адилаар үйл үгээ өөрчилсөн (чи Миний найз уу?). Тэр яагаад ийнхүү үйлдэв? (ишлэл 17)
3. Яагаад Петр Есүсийг гурав дахь удаагаа асуухад гунигтай болсон бэ? Байж болохуйц тайлбарыг бод.
  - Петр Есүс Эзэнээсээ уравхаасаа өмнө Түүнд хайртайдаа 100% итгэлтэй байсан. Та тэр үед Петрийн хайр үнэн байсан гэж боддог уу? Өөрийн тайлбарыг өг.
    - Харин одоо Пэтр Есүсийг хайлдаг шалтгаан нь юу байж болох вэ?
4. Есүс өнөөдөр ч мөн: “Чи Намайг хайрладаг уу” гэсэн адил асуултыг танд тавьж байна. Таны хувьд энэ асуултанд хариулах нь амархан уу? эсвэл хэцүү юу? Яагаад?
5. Яагаад Есүс энэ асуултыг бусад шавь нарынхаа өмнө асуусан бэ?
  - Яагаад Есүс Пэтрт гурван удаа үүрэг өгч байна вэ?
  - Хэрэв энэ ярилцлага болоогүй байсан бол Петрийн ирээдүй хэрхэн өрнөх байсан бол?
6. Бодит байдалд Христийн цуглааны хоньдыг халамжилж, хургыг нь тэжээнэ гэдэг нь юуг илэрхийлдэг вэ?
  - Энэ үйл явдал дараа нь Петрийн сургаалд ямар нөлөө үзүүлсэн бэ?
  - Есүсийг хайрладаггүй Христчин хоньчинийг төсөөлөөд үз. Тэр үүргийг хэрхэн биелүүлэх вэ?
  - Энэ хэсгийн дагуу үзвэл Есүс ямар хүмүүст үүрэг даалгавар өгдөг вэ?
7. Петр өмнө нь үхлийн айдсаасаа болж Есүсийг нэг сар голсон. Ишлэл 18 ба 19-д Есүс Петрийг тамлуулан алагдана гэдгийг зөгнөсөн. Та Петрийг энэ илчлэлийг хэрхэн хүлээн авсан гэж боддог вэ? Мөн үлдсэн амьдралынхаа тухай мэдсэнээр хэрхэн амьдарсан гэж боддог вэ?
  - Яагаад Петр үхлээс айх хэрэггүй болсон вэ?

- Хэрэв та зөвхөн амьдралаараа төдийгүй үхлээрээ Бурханыг алдаршуулах болно гэдгээ мэдсэн бол үүнийг хэрхэн хүлээн авах вэ (ишлэл 19)?

8. Түүнчлэн та ч бас Петр шиг Есүсээс урвасан байж магадгүй. Тэгвэл Есүс өнөөдөр танд Петрт тушаасанчлан “Намайг дага” гэж хэлж байна. Та Түүнд юу гэж хариулах вэ?

.